



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Хавдар судлалын үндэсний төвийн 2020 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар нийт 226 925 277 (хоёр зуун хорин зургаан сая есөн зуун хорин таван мянга хоёр зуун далан долоон) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэхүүд санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт болон дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

2.2. Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцуулж, зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх;

2.3. Нийслэлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хийгдсэн шинэчлэлтийн ажлын үр дүнд устсан, ашиглалтгүй болсон 7 нэр төрлийн нийтийн эзэмшлийн байгууламжийн хөрөнгийг данснаас хасуулах;

2.4. Хавдар судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эзэмшил газар дээр, хавсралтад дурдсан хуулийн этгээдийн зөвшөөрөлгүй барьсан барилгын өргөтгөл хэсэг болон хашааг эрх бүхий байгууллагаар албадан буулгуулж, төрийн өмчийн газрыг чөлөөлүүлэх арга хэмжээ авах;

2.5. Элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнээ нөхсөн, цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох;

2.6. Шинээр олж авсан 79997 м.кв талбай бүхий газар эзэмших эрх болон 2419 м.кв талбай нэмэгдсэн газар эзэмших эрхийн өөрчлөлтийг тус тус үнэлж данс бүртгэлд тусгах;

2.7. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

132002321


3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА


 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 25 дугаар сарын 28 -ны өдрийн
 285 дугаар тогтоолын хавсралт

**Хавдар судлалын үндэсний төвд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил,
дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт**

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Батлагдсан төсвийн зардлын эдийн засгийн ангилал, зориулалтыг зөрчиж зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	30.9	Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Төсвийн тухай хуулийн 41.2.2, 41.2.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 4.2	Төсвийн гүйцэтгэлийн үед зардлын хяналтыг хэрэгжүүлэхэд байгууллагын удирдлага анхаарч ажиллах, урсгал шинжтэй зардлаас хөрөнгө бэлтгэхдээ зөвшөөрөл авах
2	Нийслэлийн хөрөнгө оруулалтын шинэчлэлтээр ашиглалтгүй болсон нийтийн эзэмшлийн байгууламжийг данс бүртгэлээс хасаагүй	196.0	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71 дүгээр хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журам	Хөрөнгө оруулалт, шинэчлэлтийн дүнд буулгасан, ашиглалтгүй болсон, үндсэн хөрөнгийг тухай бүр акталж данснаас хасч байх
3	“Энэр мед” ХХК, “Өргөө 69” СӨХ, “Шинэ зуун” СӨХ болон Хүрээ хаус ХХК зэрэг нь төрийн өмчит байгууллагын эзэмшил газарт түрж орж хашаа, барилга байгууламж барьсан, байрлуулсан	-	Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, НИТХ-ын 2019 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журам” 24/17 тогтоол	Эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, эзэмшил газрын бүрэн бүтэн байдлыг хангах, газар чөлөөлүүлэх арга хэмжээ авах
НИЙТ ДҮН:		226 925 277 (хоёр зуун хорин зургаан сая есөн зуун хорин таван мянга хоёр зуун далан долоон) төгрөг		